

УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

ТАЙЛАН

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 74-т “Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2025 онд хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан.

Улсын Их Хурлаас Улсын нисэхийн тухай хуулийг анх 2003 онд баталж, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, бусад хууль тогтоомжид нийцүүлэн 2004, 2013, 2015, 2018 болон 2023 онд тус тус нэмэлт, өөрчлөлт оржээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох эрх зүйн зохицуулалтуудыг удирдлага болгон Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан ба улсын төсвөөс гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-д үндэслэсэн.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог аргачлалын дагуу тооцох судалгааны зорилго нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн байгууллагад үүсэх зардлын ачааллыг тооцож, цаашид гарах ачааллыг багасгах санал боловсруулахад оршино.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримталсан. Үүнд:

- Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах зэрэг юм.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 6.1.4-т “улсын агаарын хөлөг, хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгслийг гаалийн татвараас чөлөөлөх журмыг батлах”, 6.1.5-д “Улсын нисэхийн нисгэгч, инженер техникчид болон нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний жагсаалт, цалингийн хэмжээ, итгэлцүүрийг тогтоох” гэж Засгийн газрын бүрэн эрхэд тус тус заасан.

Дээр дурдсан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд төсөвт нэмэлт зардал гарахгүй бөгөөд батлан хамгаалах салбарын батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 20.1-д “Батлан хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.”, Зэвсэгт хүчний тухай хуулийн 18.1-д “Зэвсэгт хүчнийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” гэж заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, мөн зүйлийн 2-т “Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд

алба хаах журмыг хуулиар тогтооно.”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалтад “улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Тавдугаар зүйлийн Зорилт 5.2-т “Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна” гэсэн зохицуулалтуудыг бүрэн хэрэгжүүлэх юм.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхэд улсын төсөвт ямар нэмэлт зардал үүсэхгүй болно.

---oOo---